



АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Ж.Назгүл
Утас: 99668909
Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Цагдаагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-ноос 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-нээс 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 26-нд Цагдаагийн газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цагдаагийн газрын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх хууль, Тамхины хяналтын тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх, алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цагдаагийн газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Цагдаагийн газрын 2017 оны төсвийг Хууль зүйн сайдын төсвийн багцаас Цагдаагийн Ерөнхий газраас аймгийн Төрийн сан дахь харилцах дансаар олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 27-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад аймгийн Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Цагдаагийн ерөнхий газраас боловсруулж харьяа байгууллагуудад мөрдүүлж ажилладаг байна.

Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүү тооцоолох” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цагдаагийн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 24 “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Цагдаагийн Ерөнхий газраас аймгийн Төрийн сан дах харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аймгийн Цагдаагийн газрын төсвийн захирагч нь 2017 онд 2069,5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 2012,1 сая төгрөгийг улсын төсвөөс, 57,3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн зарцуулахаар тусгагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2012.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 46.7 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 11.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж бүгд 2049,7 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж, батлагдсан төсвөөс 19.8 сая төгрөгийн бага зарлага гаргасан байна.

Батлагдсан төсвөөс гадна аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10.8 сая төгрөгийн, Дээд шатны захирагчаас 13.7 сая төгрөгийн, Онцгой байдлын газраас 3.0 сая төгрөгийн, баяр наадмын зөвшөөрлөөс 9.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ.

Цагдаагийн ерөнхий газраас 16,6 сая төгрөгийн бараа материал, 48.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэгүй төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд цалингийн зардал 81 хувь буюу 1066.5 сая төгрөгийг, НДШ 2 хувь буюу 34.2 сая төгрөгийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5 хувь буюу 94.7 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардал 5 хувь буюу 112.4 сая төгрөгийг, урсгал шилжүүлэг 2 хувь буюу 38.8 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд 151 орон тоогоор батлаж, гүйцэтгэлээр 151 орон тоогоор ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Цагдаагийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар 1970.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитын дүнгээр дутуу байршуулсан мэдээллийг бүрэн нөхөж мэдээллийн цахим хуудаст байршуулжээ. Шилэн дансны судалгааг shilendans гэсэн файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 27 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн Цагдаагийн газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, халаалт, тээвэр шатахуун, түлээ нүүрс, халаалт, бараа материал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд онцлохоор үйл явдал болоогүй байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илэрээгүй. Материаллаг бус дараах алдаа илэрсэн. Үүнд:

1. Тайлант онд ажилчдад олгосон урьдчилгааны тооцоог шалгаж үзэхэд олгосон 250.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй, санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй орхигдуулж Төсвийн тухай хуулийн 6.4.8, 16.5.7, 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4, 14.4.1, 14.4.2 дах заалтуудыг зөрчжээ.

Шийдвэрлэсэн нь: Суутгаж аваагүй орхигдуулсан 250.0 мянган төгрөгийн урьдчилгааг нөхөн төлүүлэхээр акт тогтоов

2. Тайлант онд тэтгэвэрт 4 хүн гарч, оронд нь 4 хүнийг шинээр томилсон байна.Энэ нь УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1-ийн 6 дах заалттай зөрчилдөж байна.

3. Дээд шатны байгууллагаас үнэгүй ирсэн 7.6 сая төгрөгийн шатахууны картыг бараа материалын тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалд оруулж буруу илэрхийлсэн, өрөөний тохижилт хийхэд зарцуулсан 2.9 сая төгрөгийн урсгал засварын материалын үнийг Үр дүнгийн тайланд тусгасан боловч бараа материалын тодруулга тайланд тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд засвар хийхийг зөвлөв

4. Жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн 19.8 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэгийг Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд 213301 кодоор урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд бичсэн

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд засвар хийхийг зөвлөв

5. Сангийн сайдын 2006 оны 388 тушаалын хавсралтаар баталсан санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулгыг загварын дагуу бэлтгэж ирүүлээгүй байна

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Зөвлөмж

Зөвлөмж өгөхөөр асуудал гараагүй болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Цагдаагийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН 2018.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК 2018.02.24

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ж.НАЗГҮЛ 2018.02.24